



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2024 оны 02 сарын 20 өдөр

Дугаар А/112

Арвайхээр сум

Үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.2, 50 дугаар зүйлийн 50.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Эрүүл мэндийн төвийн барилгын өргөтгөл (Өвөрхангай, Зүүнбаян-Улаан сум) ажлын тендерийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга: Д.Шивааннүрдэв (аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Эрүүл мэндийн газрын дарга)

Гишүүд: Б.Мөнхбат (аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга)

Ц.Оюун (Иргэний төлөөлөл) (зөвшилцсөнөөр)

Г.Гантөмөр (Оновчтой хөгжил ТББ-ын тэргүүн) (зөвшилцсөнөөр)

Нарийн бичиг: Т.Эрдэнэсүрэн (аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Худалдан авах ажиллагааны газрын Худалдан авах ажиллагаа, дотоод хяналт шалгалт хариуцсан ахлах мэргэжилтэн)

2. Худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, мэдэгдэл, гэрээний төслийг өргөн мэдүүлэхийг Үнэлгээний хороо (Д.Шивааннүрдэв)-д даалгасугай.

3. Тендер шалгаруулалттай холбоотой баримт бичгээр хууль тогтоомжийн дагуу архивын нэгж бүрдүүлж, Архив, бичиг хэргийн ажилтанд хүлээлгэн өгөхийг Үнэлгээний хорооны нарийн бичиг (Т.Эрдэнэсүрэн)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



И.ДОРЖСҮРЭН

0224 11 0233